

ШАРАНГАДЫН АГУЙН БИЧЭЭС

О. Дэмчигмаа*
Х. Бямба-Од**

Манай орны өргөн уудам нутагт хад чулуу, агуйн хананы бичээс олонтаа тохиолдоно. Эдгээрийг эрдэмтэд тал бүрээс нь судлан шинжилж, судалгааны эргэлтэд оруулсаар иржээ. Сүүлийн үед эх бичиг судлалын хүрээнд хээрийн судалгаа, дадлага хийх явцад иймэрхүү бичээсийг олж мэдээлэх, танилцах асуудалд илүүтэйгээр анхаарал хандуулж буй билээ.

Бид энэхүү өгүүлэлдээ Дундговь аймгийн төвөөс баруун урагш 70 гаруй км, Хулд сумын нутаг (E105°59'14,1; N45°09'47,6; dtd1232m)-т орших Шарангадын агуйн бичээсийн талаар толилуулахыг зорилоо. Шарангадын агуй Хулд сумын төвөөс зүүн тийш 35 км зайтай бөгөөд агуйн амны өндөр нь 12м орчим, өргөн нь 3м, доторх тойрог нь 10 м орчим урттай. Хэмжээгээр жижгэвтэр уг агуйд монгол, төвд бичээс нэлээд буй. Бусад хад чулууны бичээст ихэвчлэн маанийн зургаан үсэг, тарнийг дахин давтан бичсэн байдаг бол Шарангадын агуйн бичээс нь хэд хэдэн бурхадын зүрхэн тарни, маанийн үсэг, залбирал, мигзэмийг төвд, монгол, али гали үсгээр бичсэн байхын зэрэгцээ зарим бурхадын ерөөл магтаал, мөргөлийн хэсгийг толгой холбон шүлэглэж бичсэнээрээ онцлог юм.

Агуйн ам халз урагш шахам, нар руу харсан байрлалтай тул өдөр гэгээ сайн тусдаг бөгөөд агуйн дотор байдал нь бичээсийг нар, салхи, бороонд бага элэгдэж, гандах таатай нөхцөлтэй хэдий ч зарим нь баларч бүдгэрээд унших боломжгүй болжээ. Аргаль янгир хотолдог бололтой, шар бууц хоргол ихтэй, тоос их дарсан байх тул зарим бичээсийг олж үзэж чадаагүй байж болох хэдий ч чамлахааргүй тооны бичээс нь уншихад боломжийн тод байсан юм. Бичээсийг хар бэхээр бичсэн байх агаад норгож тодруулан зураг авахад арилахгүй байв. Бид энд хуулбарлан авсан бичээсээ бүгдийг оруулсангүй, гол төлөв том хэмжээний, тодовтор, бүтэн бичээсийг оруулахыг чухалд үзлээ.

Ингээд монгол, төвд бичээсийг эрдэм шинжилгээний галигаар галиглан, шинэ үсгээр хөрвүүлэн, төвдөөс орчуулж, тайлбарлан хүргэе.

*Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сургууль

** Дундговь аймгийн музей

Монгол бичээсүүд:

Нэг.

Авианы галиг:

- | | |
|---------------------------------------|----------------------------------|
| 1. ariy-a | 25. adistai, nisvanis-un simnu-i |
| 2. balo | 26. daruyči, ariy-a balo-dur |
| 3. nereti | 27. mörgümü. om ma vi [=ni] |
| 4. abida | 28. amurlingyui gegen niyur |
| 5. burqan | 29. tai, asarangyui mingyan |
| 6. tetimti | 30. mutur-tai [=muturtai], amur |
| 7. arban nigen | 31. orun-dur kürgegči |
| 8. niyur | 32. ariy-a balo-dur |
| 9. tu | 33. mörgümü, om mavi [=mani] |
| 10. ariy-a | 34. badarangyui gegen |
| 11. balo-dur | 35. gereltei, badam-a |
| 12. mörgümü | 36. lingqu-a-yin |
| 13. om ma_a | 37. düri-tei, |
| 14. vi = [ni] | 38. basa qoyidu |
| 15. bad mi qung = [hum] | 39. dur |
| 16. tunumal gegen | 40. učaraq |
| 17. niyurtai tuyuluysan | 41. man-u boltuyai |
| 18. burqan titemtei | 42. uva ma vi [=ni] bad |
| 19. tonilyayči nirvan | 43. mi qung |
| 20. ariy-a | 44. qamuy amitan-i |
| 21. balo-dur mörgümü | 45. getülgegči |
| 22. om ma vi [=ni] | 46. nom bui-dur |
| 23. qung. = [hum]. nigülesküi mingyan | 47. |
| 24. nidütei , nigül-i arilyayči\ | |

Шинэ үсгээр:

Арьяабал нэрт
Авид бурхан титэмт
Арван нэгэн нигуурт
Арьяабалд мөргөмүй.

Ум ма ни бад мэ хум.

Тунамал гэгээн нигууртай
Туулсан бурхан титэмтэй
Тонилгогч нирваан [түшиг]
Арьяабалд мөргөмүй.

Ум ма ни бад мэ хум.

Нигүүлсэхүй мянган нүдтэй
Нүглийг арилгагч адистай
Нисваанисын шумнусыг дарагч
Арьяабалд мөргөмүй.

Ум ма ни бад мэ хум.

Амирлангуй гэгээн нигууртай
Асрангуй мянган мутартай
Амар оронд хүргэгч
Арьяабалд мөргөмүй.

Ум ма ни бад мэ хум.

Бадрангуй гэгээн гэрэлтэй
Бадам лянхуан дүртэй
Бас хойтод учрах маань болтугай.

Ум ма ни бад мэ хумв

Хамаг амьтныг гэтэлгэгч

.....

.....

Хоёр.

- | | |
|--------------------|------------------------------|
| 1. görügesün | 10. legsen ene |
| 2. metü | 11. ori juryan [=...iryuyan] |
| 3. kücün | 12. jüyil amitan-u |
| 4. tü | 13. tonilyayçi |
| 5. arslan | 14. ketü |
| 6. un dayun | 15. sigemüni |
| 7. luy-a | 16. yin ene |
| 8. tegülder erkin | 17. ayui |
| 9. bisireltü titem | |

Шинэ үсгээр:

Гөрөөсөн мэт хүчит
 Арслангийн дуун лугаа төгөлдөр
 Эрхин бишрэлт титэмлэсэн
 Энэ орь зургаан зүйл амьтны тонилгогч
 Хэт Шигэмүнийн энэ агуй
 Эдүгээ Навагданзан би хийгээд
 Эх хамаг амьтны тусад суусан

Эрхэм бишрэлт даяанч лам бид харин
 Энэ агуйдаа сууж
 Эх хамаг амьтан дахин
даруй
х болтугай
 Ум ма ни бад мэ хум.

Гурав.

1. yeke qubilyan
2. u sar-a-yin
3. qonuy tutum
4. dur ürgül...i
5. sakisuyai kemen
6. ögületügei

Шинэ үсгээр:

Их хувилгааны сар¹-ын шинийн хоног тутамд
 үргэлж сахисугай хэмээн өгүүлтүгэй.

Дөрөв.

1. blam-a-dur
2. mörgümü, burqan
3. dur mörgümü
4. nom-dur mörgümü
5. bursang quvaray
6. ud-dur-iyar mörgü
7. ged maytaju biçigsen-ü
8. mayad-iyar adis-
9. tidlan soyur
10. qa_a

Шинэ үсгээр:

Ламд мөргөмүй
 Бурханд мөргөмүй
 Номд мөргөмүй
 Бурсан хуврагууддаа мөргөөд
 Магтаж бичсэний магадаар
 Адистидлан соёрх.

¹ Цагаан сарыг ингэж хэлдэг.

Тав.

1.	sedkisi-ügei	
2.	yeke örüsiyenggüi, sang bariy	Шинэ үсгээр:
3.	үчин ары-а	Сэтгэшгүй их өршөөнгүй
4.	avalokitisivari	Санг баригчин
5.	gkir ügei medeküi	Арьяалокитешвара
6.	erketü çasutan-u merged-ün oroi	Хиргүй мэдэхүй эрхт
7.	yin çimeg songkavba, sumadi	Цастны оройн чимэг Зонхова
8.	kirti-yin köl-dür	Сумади Кирти-ийн хөлд
9.	sögüdün mörgümü.	сөгдөн мөргөмүй.

Богд Зонхова-гийн залбирлын эрхэм болсон, 4 шадны мигзэм байна. Амьтан бүхнийг алагчлалгүй өршөөл гарах орны их сан болсон Жанрайсиг, мэдэгдэхүүний орон бүхэнд мунхралгүй айлдахын эрхт болсон Манзушир бурхад лугаа ялгалгүй, ном бүхнийг үлдээлгүй болгоохуйгаараа тэнцэшгүй, Цаст Төвдийн оройн чимэг болсон Зонхова Лувсандагвын залбирал болно.

Жанрайсиг бурханы алдрыг санскритаар Арьяалокитешвара хэмээдэг. Сумади кирти хэмээх нь мөн санскрит үг бөгөөд төвдөөр ལྷོ་བཟང་གྲགས་པ། *blo bzang brag pa* буюу Богд Зонхова-гийн сахилын алдар нэр юм.

Зургаа.

1.	biyen-dü	8.	boltuyai
2.	γurban nom	9.	sedkil-dür γurban
3.	tu debel-ün	10.	surtal-yin öljei qutuy orusiqu
4.	öljei qutuy	11.	boltuyai öljei qutuy tegüs
5.	orusiqu boltuyai	12.	çü edüge bid amuyulang sain
6.	kelen-dür γurban ayimay saba	13.	boltuyai. Ma nga lam
7.	yin öljei qutuy orusiqu		

Шинэ үсгээр:

Биенд гурван номт дээлийн өлзий хутаг орших болтугай
Хэлэнд гурван аймаг савын өлзий хутаг орших болтугай
Сэтгэлд гурван суртлын өлзий хутаг орших болтугай
Өлзий хутаг төгсч эдүгээ бид амгалан сайн болтугай. Мангалам.

Долоо.

1.	burqan nom	
2.	quvaray γurban	Шинэ үсгээр:
3.	erdeni	Бурхан, ном, хувраг гурван эрдэнэ минь ээ
4.	blam-a mini_e e	Адислан соёрх.
5.	adislan soyur	
6.	ha	

Чухаг дээд гурав буюу “Тончигсүм”-д аврал одуулах мөргөлийн үг.

Найм.

1. quluγan-a üker
2. bar taulai luu
3. moyai
4. mori
5. qoni miči
6. takiy-a noqai
7. yaqai

Шинэ үсгээр:

- Хулгана, үхэр
бар, туулай. луу
могой
морь
хонь, мич
тахиа, нохой
гахай

Монголоор бичсэн маань, бурхадын зүрхэн тарниуд:

1. *om banazi so ha*
Ум банази суухаа.
2. *om ma ni pad mi hum*
Ум ма ни бад мэ хум.
3. *om a ma ra ni dza wa_a da_a so ha.*
Ум а ма ра ни зи ван ди е суухаа.

Энэхүү тарни бол Аюуш бурханы зүрхэн тарни бөгөөд эрүүл энх, урт удаан наслахыг хүсэн ерөөж уншдаг.

Төвдөөр: ཨོཾ་ཨ་མ་ར་ཐི་ཇི་ཐབ་ཏི་ཡི་སྣ་རྒྱ།

4. *om a_a houn.*

*badzar gürü badma
sedi houn*

Ум аа хум. Базар гүрү бадма седи хум. Ловон Бадамжунай бурханы зүрхэн тарни юм.

Төвдөөр: ཨོཾ་ཨུལ་རྩུ་བཛ་ལུ་བུ་བུ་སྐྱི་རྩུ་

5. *om ma vi pad mi [hum]*

Ум ма ни бад мэ [хум].

ཨོཾ་མ་ཐི་བདེ་རྩུ།

Жанрайсий бурханы зүрхэн тарни.

a_a ra ba dza na di

А ра ба за на ди.

ཨོཾ་ཨ་ར་བ་ཙ་མ་རྩུ།

Манзушир бурханы зүрхэн тарни.

om badzar bani houn padi.

Ум базар ванн хум пад.

ཨོཾ་བཛ་བུ་ཐི་རྩུ་ལྟ།

Очирваань бурханы зүрхэн тарни.

Om a ma rani ivan da_a so ha_a

Ум а ма ра ни зиван да суу хаа.

ཨོཾ་ཨ་མ་ར་ཐི་ཇི་ཐབ་ཏི་ཡི་སྣ་རྒྱ།

Аюуш бурханы зүрхэн тарни.

6. *ta_a da ya da*

om bahavadzi_a

biha_a dzi maha_a

baha_a dzi_a baha_a

dzi_a ra na_a dza

sa mida kadi

so ha_a

нэрс, өмнө, умар, дорно зүгийн орныг гийгүүлэгч, наран луу, саран гарди, арслан гэх мэт үгс бас буй. Үүнээс ажиглавал, дөрвөн зүгийн гурав, дөрвөн хүчтэний мөн гурвын нэр байгаа нь сонирхолтой. Нэгийг нь бичээгүй ч юм уу эсвээс бид олж үзээгүй ч байж магад. Хэдэн төвд, монгол бичээс утга агуулгаараа тохирч байна. Өөрөөр хэлбэл, монгол бичээсийн зарим нь төвд бичээсийн орчуулга байх бөгөөд толгой холбосон, уран яруу монгол шүлгийн хэлбэртэй ажээ. Бичээсийн агуулгаас үзэхэд уг агуйд бясалгалд сууж байсан лам нар нууц тарни, увдист нэлээд сайн мэргэшсэн бололтой.

“Шарангад” хэмээх нэрийн тухайд “Шар хад” гэсэн үгийн дуудлага сунжирч хэлэгдэх болсноос ийн нэрлэгдэх болсон байж болох талтай. Ойр тойрон нь талархаг бөгөөд тэр орчимдоо шар, сааралдуу өнгийн өндөр хадан толгодтой ажээ.

Нөгөөтэйгүүр “Монгол улсын аймгууд байгуулагдсан товч түүх. Хавсралт-1”-д Дундговь аймгийг “...БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941.12.02-ны өдрийн 81дүгээр хурлаас Өмнөговь аймгаас 8, Төв аймгаас 7, Дорноговь аймгаас 3 сумаар бүрэлдсэн аймгийг анх Шарангад аймаг нэртэй байгуулахаар шийдвэрлэв. Ембүү Дэрсэнэ ус хэмээх газар байгуулагдсан...” гэснээс үзвэл аймгийн анхны нэрээс үүсэлтэйгээр тус агуйг ингэж нэрлэсэн ч байж болох. Учир нь аймгийн шавыг анхлан тавьж байгуулсан Дэрсэнэ ус нэртэй газар нь “Шарангадын агуй”-гаас нэг их холгүй юм.

Агуйн хадны бичээсийн зэрэгцээ өлзий хээ, хас тэмдэг, сарны дээд талд нарыг дүрсэлсэн байх аж. Төвд үг үсгийг монголоор али гали үсгээр бичсэн байдал, түүнчлэн санскрит үг орчуулгыг ашигласан байгаа байдал нь бичигчийн эрдэм мэдлэгийн цар хүрээг илэрхийлж байна. Бичгийн хэв байдлыг харахад ганц хоёроос илүү хүн бичээгүй болов уу гэлтэй. Гэхдээ бичээст “... Шигэмүнийн энэ агуй эдүгээ Навагданзан би хийгээд эх хамаг амьтны тусад суусан эрхэм биширэлт даяанч лам бид харин энэ агуйдаа сууж...” гэснээс үзвэл нэг бус бясалгалч лам сууж байсан бөгөөд бичсэн гол хүн нь Наваанданзин хэмээх лам байсан бололтой. Мөн хүний нэр гэмээр тусад нь төвд үсгээр бичсэн Лувсанчойбүн, Дашбал гэх зэрэг үг буй.

Он цагийн хамаатлыг бичээст гарч буй “Улагчин тахиа жил сэста |цэста| сарын сайн өдрөө бичвэй” гэснээс үндэслэвэл, Монголд бурханы шашин гурав дахь удаагаа өрнөн дэлгэрсэн үе болон али гали үсэг зохиогдсон 1587 оноос хойшхи хугацаанд улаагчин тахиа жил 1597-1957 он хүртэл нийт долоон удаа тохиож байна. Харин бурханы шашны их хөлгөн судрууд болох Ганжур, Данжурьг монгол хэлнээ орчуулсан XVIII зуунаас хойш али гали үсгийг бүр өргөн хэрэглэх болсон гэж бодохул уг бичээсийг 1837 юмуу 1897 онд бичсэн болов уу гэж таамаглаж байна. Цэста сар бол морь сар болно.

Цаашид агуйн бичээсийг дахин сайн нягтлан үзэж, ойр орчинд нь ямар хийд байж, тэнд ямар лам нар шавилж, бясалгалд сууж байсан болохыг холбогдох нэрээр мөшгин, бичигч болон он цагийг илүү нарийн тодруулж үзвээс зохилтой гэж бодно.

Ашигласан эх сурвалж

1. Шагдарсүрэн. Ц. *Монголчуудын үсэг бичгийн товчоон*. Уб. 2001.
2. Бүрнээ. Д, Энхтөр. Д. *Товд-монгол толь*. Уб. 2000.
3. *Буддын шаашин соёлын тайлбар толь*. Хамтын бүтээл. Уб. 1999.
4. *Бурханы шаашинны оврийн дэвтэр*. “Лам нарын сэтгүүл” хэвлэлийн газраас эрхлэн гаргав. Уб. 2010.
5. *rims nad zhi ba'i gzungs sngags*.

Resume

In the article the author researched inscriptions of Sharangad cave in Dundgobi aimag. There are a lot of Old Mongolian (Mongolian script) and Tibetan inscriptions about spells and prayers which related to Buddhism, especially Lamaism. The transcription, translation and some commentaries on the inscriptions have been made by the author.

Монгол бичгээрх бичээсээс

